

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-13</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>14-29</i>
<hr/>	
<i>1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>14-22</i>
<i>2. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл / Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	<i>22-29</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 15-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл- /1/**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68,1 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 51 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Анандбазар;

Томилолттой: Ц.Даваасүрэн, Б.Чойжилсүрэн;

Тасалсан: Ш.Раднаасэд.

Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, мөн яамны Хүн, амын хөгжлийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Жавзанжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Н.Мөнхзэсэм, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

1.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.7 дахь хэсгийн “энэ хуульд заасан журмаар” гэсний өмнө “энэ хуулийн 9.2-т нийцүүлэн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Үр дүн гүйцэтгэлийн төлөвлөлтийн аргуудад шилжиж байгаатай холбогдуулан судалгаа тооцооллыг нарийвчлан судалж төслийн үзэл баримтлалыг тодорхой болгох үүднээс Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 16 дугаар зүйлийн 16.4, мөн зүйлийн 3 дахь заалтын 57 дугаар зүйлийн 57.18 дахь хэсэг, мөн зүйлийн 4 дэх заалтын 78 дугаар зүйлийн 78.1, 78.3 дахь хэсгүүдийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 8
Бүгд: 13
38.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 78 дугаар зүйлийн 78.4 дэх хэсэгт тусгагдсан асуудлыг “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусган зохицуулахаар төслөөс хасаж, мөн заалтын 78.2 дахь хэсгийг төслийн 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсгийг 2025 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Тэмүүлэн: Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.7 дахь хэсгийн “түүний хэмжээ” гэснийг “албан тушаалын цалингийн хэмжээ” гэж, 3 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж тус тус

өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлээс “зүйл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаан 14 цаг 07 минутад түр завсарлаж, 14 цаг 46 минутаас үргэлжлэн хуралдав.

Хоёр.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 17.2 дахь хэсгийн “6, 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхтэй” гэснийг “6 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэхтэй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “сум” гэсний дараа “баг” гэж” гэснийг “6.2 дахь хэсгийн Аймаг, нийслэл” гэсний дараа “сум” гэж, “сум” гэсний дараа “баг гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “, Эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зам, тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Х.Булгантуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.6 дахь заалтын “орон нутгийн салбар нэгжийг нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын уялдааг сайжруулах” гэснийг “энэ хуулийн 20.1-д заасан төвийн үйл ажиллагааны салбар дундын хамтын ажиллагааны зохицуулалтыг хангах,” гэж өөрчлөн “, ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Х.Булгантуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.7 дахь заалтын “аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл салбарууд дахь Залуучуудын хөгжлийн зөвлөлүүдийг” гэснийг “аймаг, нийслэл, сум, дүүргийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Х.Булгантуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.8 дахь заалтын “олон улсын байгууллагын” гэснийг хасаж, “төрийн бус” гэсний дараа “байгууллага” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Х.Булгантуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.10 дахь заалтын “Залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээг аймаг, дүүрэг, сум дахь Залуучуудын хөгжлийн төвүүдээр дамжуулан хүргэх, энэ хуульд заасан чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоо” гэснийг “аймаг, дүүрэг, сум дахь төвийн хэрэгжүүлэх энэ хуулийн 20.2-т заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.11 дэх заалтын “Энэ хуульд заасан чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоо” гэснийг “энэ хуулийн 19.1-д заасан зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйл буюу 20.2.2 дахь заалтын “гаргах үйл ажиллагаанд бүх түвшинд оролцож саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх боломжийг бүрдүүлэх” гэснийг “гаргахтай холбоотой саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйл буюу 20.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.2.5.гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, тулгамдсан бэрхшээлийг даван туулах талаар залуучуудад сургалт явуулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “үйлчилгээ болон энэ хуульд заасан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйл буюу 20.4 дэх хэсгийн “төвийг” гэснийг “төвийн үйл ажиллагааны зардлыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйл буюу 20.2.3 дахь заалтын “сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн” гэснийг “сонирхлын бүлгийн” гэж, 20.2.7 дахь заалтын “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 20.3 дахь хэсгийн “, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоогоор” гэснийг “залуучуудын иргэний нийгмийн байгууллагаар” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 40.5 дахь хэсгийн “хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд тавигдах” гэснийг “хуулийн 23.2-т заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 46 дахь хэсгийн “томилсон тохиолдолд байгууллага дэд даргатай байна” гэсний дараа “энэ тохиолдолд Төлөвлөлтийн тухай хуулийн 50.5.1 дэх хэсэг хамаарахгүй” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 40.7 дахь хэсгийн “заасан байгууллагын” гэснийг “заасны дагуу томилогдсон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Баделхан, Х.Булгантуяа, Л.Мөнхбаатар, Б.Пүрэвдорж нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3.15 дахь хэсгийн “судалгаа эрдэм шинжилгээ туршилт зохион бүтээхтэй холбоотой” гэснийг “шинжлэх ухааны суурь хавсарга технологи, хөгжүүлэлтийн туршилт судалгаа болон инновацын судалгааны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 6

Бүгд: 12

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн санал хураалтаас хоцорсон тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “баталсан өдрөөс” гэснийг “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Долоо.Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Найм. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дэх заалтын “тогтоолын 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 2.4, 2.5 дахь дэд заалт” гэснийг “тогтоолд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт, мөн тогтоолын 2 дахь заалтад 4 дэх дэд заалт тус тус” гэж, мөн заалтын 4 дэх дэд заалтыг 3 дахь заалт болгон тус заалтын “хүүхдэд” гэснийг “хүүхэд бүрд” гэж, “нөхөн олгох;” гэснийг “нөхөн олгосугай.” гэж тус тус өөрчлөн, мөн заалтын “хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн гаргасан хүсэлтэд үндэслэн” гэснийг хасаж, 5 дахь дэд заалтыг 4 дэх дэд заалт болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Жавхлан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 8
Бүгд: 12
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн нарын гаргасан, Төслийн 2 дахь заалтын “Мөн тогтоолын” гэснийг “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолын” гэж өөрчлөн, төсөлд “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолын 3 дахь заалтын дугаарыг “4” гэж өөрчилсүгэй.” гэсэн агуулга бүхий 3 дахь заалт нэмж, төслийн 3 дахь заалтын дугаарыг “4” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “тогтоолын 2 дахь заалтад дор дурдсан агуулгатай 2.4, 2.5 дахь дэд заалт” гэснийг “тогтоолд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт, мөн тогтоолын 2 дахь заалтад 4 дэх дэд заалт тус тус”

гэж, мөн заалтын 4 дэх дэд заалтыг 3 дахь заалт болгон тус заалтыг “нөхөн олгох” гэснийг “нөхөн олгосугай” гэж, 5 дахь дэд заалтыг 4 дэх дэд заалт болгон дугаарыг тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ес. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн тогтоох хэсгийн “хэсэгт заасныг” гэснийг “хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл / Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын дарга, Тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүү, төсөв судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг

зохицуулах газрын дарга Б.Алимаа, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Н.Мөнхзэсэм, Ё.Энхсайхан мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний, газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх нар байлцав.

Төсвийн төслийн талаар Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат танилцуулав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн төслийг хэлэлцэн санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Ёс зүй, сахилга хариуцлагын, Инновац, цахим бодлогын, Нийгмийн бодлогын, Төрийн байгуулалтын, Үйлдвэржилтийн бодлогын, Хууль зүйн болон Эдийн засгийн байнгын хороодоос Төсвийн байнгын хороонд тус тус ирүүлснийг Байнгын хорооны гишүүдэд тарааж танилцуулсан тул Байнгын хороодоос ирүүлсэн санал, дүгнэлтийг сонссонд тооцёе гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	6
Бүгд:	12

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	4
Бүгд:	12

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12

75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Байнгын хороодоос ирүүлсэн санал, дүгнэлтийг сонссонд тооцов.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлт болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “IX.1.112.Ард Аюушийн өргөн чөлөөний гэрэлтүүлэг /Улаанбаатар, Баянгол дүүрэг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн нэрийн “өргөн чөлөөний” гэсний дараа “болон төв гудамжнуудын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 8

Бүгд: 12

33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа саналаа тайлбарлав.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын байгууллага болох Шадар сайдын ажлын албаны урсгал төсвийн гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, шалгах зардлын ангилал дахь хөрөнгийн эх үүсвэрээс 1,600.0 сая төгрөгийг Онцгой байдлын ерөнхий газрын багаж, техник, хэрэгслийн зардалд 1,000.0 сая төгрөг, гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны зардал 600.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 9

Бүгд: 12

25.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Л.Энх-Амгалан, Б.Чойжилсүрэн нарын гаргасан, 2023 оны төсвийн тухай хуулийн хавсралт “Х. 1.1.260 Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал, спорт заал /Хөвсгөл, Мөрөн сум, Титэм сургууль/, төсөвт өртөг 9 тэрбум 673 сая, санхүүжих дүн 3 тэрбум” гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнгээс 340 сая төгрөгийг хасаж, мөн хавсралтын “III.1.24 дэх багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Ховд/ төсөвт өртөг 3 тэрбум 611,3, санхүүжих дүн 2 тэрбум 711” гэсэн төсөл арга хэмжээний эдийн засгийн ангилалд тоног төхөөрөмж гэж нэмэн, санхүүжих дүнг 340 сая төгрөгөөр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 10

Бүгд: 12

16.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “2 дахь заалт буюу 6 дугаар зүйл” гэснийг “6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “1 дүгээр хавсралтаар” гэснийг “энэ хуулийн хавсралтаар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Б.Энх-Амгалан нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “ХШ.3.3.Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Төв, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Ховд, Хөвсгөл” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн нэрийн “Хөвсгөл” гэснийг “Говь-Алтай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 7
Бүгд: 12
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Х.1.1.65.Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2019-2023, төсөвт өртөг 7,593.9 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 1,086.3 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн төсөвт өртөг “7,593.9 сая төгрөг” гэснийг “10,246.9 сая төгрөг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжих боломжгүй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 9.1.112.“Ард Аюушийн өргөн чөлөөний гэрэлтүүлэг /Улаанбаатар, Баянгол дүүрэг” гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт

оруулахгүйгээр төслийн нэрийг төслийн нэрийг “төв замуудын гэрлэн чимэглэл Улаанбаатар, Баянгол Баянгол дүүрэг/ гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжих боломжгүй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 33 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 16 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ

ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
13 цаг 51 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн тул 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Та бүхэнд гишүүдийн ирцийг товч танилцуулаадахъя. Ганибалын Амартүвшин гишүүн, Хавдисламын Баделхан гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Болдын Жавхлан гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Салдангийн Одонтуяа гишүүн, Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, Чимэдийн Хүрэлбаатар гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны ирц бүрдсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт. Монгол Улсын 2023 төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд байгаа. Анхны хэлэлцүүлгийг хийнэ.

2 дахь нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн

даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд. 2 дахь хэлэлцүүлэг байгаа. Ингээд хэлэлцэх асуудалтай холбогдуулж санал байна уу. Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Болдын Жавхлан сайд, Хүрэлбаатарын Булгантуяа сайд, Сархадын Зулпхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Амарсайханы Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Энэ дээр нь нэмж Нарантуяагийн Баярмаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Сандагийн Тунгалагтамир Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн, амын хөгжлийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Байгальмаагийн Одонтуяа Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Дугаржавын Ренчиндорж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Буянбадрахын Жавзанжаргал Боловсрол, шинжлэх ухааны яамны Хуулийн хэлтсийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг төсөл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

1.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. 3 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Дагасан хуулиуд байгаа. Төрийн албаны тухай хууль та бүхэнд зарчмын зөрүүтэй саналуудыг гишүүдэд тараагдсан байгаа. 1 дүгээрт нь.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.7 дахь хэсгийн “энэ хуульд заасан журмаар” гэсний өмнө “энэ хуулийн 9.2-т нийцүүлэн” гэж нэмэх гэсэн саналыг гаргаж байгаа юм.

Байнгын хорооноос тодорхой хуульд нийцүүлэх үүднээс тодорхой энэ саналыг гаргаж ирж байна. Энэтэй холбоотой асуулт байна уу. Алга байна. Саналаа хураачихъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 13 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж 61,5 хувиар дэмжигдсэн байна.

2 дахь саналыг Батжаргал гишүүн гаргаж байгаа юм байна.

2.Үр дүн гүйцэтгэлийн төлөвлөлтийн аргуудад шилжиж байгаатай холбогдуулан судалгаа тооцооллыг нарийвчлан судалж төслийн үзэл баримтлалыг тодорхой болгох үүднээс төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 16 дугаар зүйлийн 16.4, мөн зүйлийн 3 дахь заалтын 57 дугаар зүйлийн 57.18 дахь хэсэг, мөн зүйлийн 4 дэх заалтын 78 дугаар зүйлийн 78.1, 78.3 дахь хэсгүүдийг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батжаргал гэсэн байна. Санал хураалт.

Асуулттай хүн байна уу. Байхгүй байна. Санал хураалт.

Булгантуяа сайд та тэгвэл санал гарчих. Булгантуяа сайдын микрофоныг өгье. Санал хураалттай холбоотой горимын санал гаргаж байна.

Х.Булгантуяа: Тэмүүлэн дарга аа, сая энэ тоног төхөөрөмж гацчих шиг боллоо. Саяны санал хураалтыг хүчингүй болгон, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Булгантуяа гишүүний саналаар саяны санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Саяны санал хураалт дэмжигдсэнгүй ээ. Тэгэхээр Батжаргал гишүүний гаргасан 2 дахь санал дэмжигдлээ гэж ойлгож байна. 61,5 хувиар.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 78 дугаар зүйлийн 78.4 дэх хэсэгт тусгагдсан асуудлыг “Хууль баталсантай холбогдуулан авах авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусган зохицуулахаар төслөөс хасаж, мөн заалтын 78.2 дахь хэсгийг төслийн 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсгийг 2025 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн санал гаргаж байгаа. Санал хураалт. Асуулттай хүн байна уу. Алга байна. Санал хураалт. 14 гишүүн санал хураалтад оролцож, 11 гишүүн дэмжин 78,6 хувиар дэмжигдлээ.

4 дэх нь найруулгын санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.7 дахь хэсгийн “түүний хэмжээ” гэснийг “албан тушаалын цалингийн хэмжээ” гэж, 3 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж тус тус

өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлээс “зүйл” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн миний бие. Санал хураалт. Асуулттай хүн байна уу. Найруулгын санал байгаа. Санал хураалт 69,2 хувиар дэмжигдлээ.

2 цаг болсон. Байнгын хорооны хурлыг 10 минут түр завсарлуулъя. Ажлын хэсгийн гишүүд түр гарч байгаарай.

ЗАВСАРЛАГА.

Байнгын хорооны хуралдааныг үргэлжлүүлъя. Сая төрийн албаны тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр зарчмын зөрүүтэй саналуудыг хурааж дууссан байгаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

2.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 5 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Асуулт асуух гишүүд алга байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 17.2 дахь хэсгийн “6, 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхтэй” гэснийг “6 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэхтэй” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн гэсэн байна.

Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал

хураалтад 12 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж 66,7 хувиар дэмжигдсэн байна.

2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Идэрбат гишүүний санал байна. Тогтохсүрэн даргад нэмэлт санал байгаа юу. Би уншаадахъя.

Төслийн 2 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “сум” гэсний дараа “баг” гэж” гэснийг “6.2 дахь хэсгийн Аймаг, нийслэл” гэсний дараа “сум” гэж, “сум” гэсний дараа “баг гэж” гэж өөрчлөх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Д.Тогтохсүрэн. Санал хураалт 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Батжаргал гишүүнээс гаргасан санал байна.

Төслийн 4 дүгээр зүйлийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “, Эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зам, тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас” гэснийг хасах гэж байгаа юм. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батжаргал. Санал хураалт. 75 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Дараагийн хууль руу оръё.

3.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 5 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 1 дүгээр зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Та бүхэнд тарааснаар бас 1 дүгээр зүйл дээр 1 санал байгаа.

“1 дүгээр зүйл.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дүгээр зүйл буюу 19.1.6 дахь заалтын “орон нутгийн салбар нэгжийг нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын уялдааг сайжруулах” гэснийг “энэ хуулийн 20.1-д заасан төвийн үйл ажиллагааны салбар дундын хамтын ажиллагааны зохицуулалтыг хангах,” гэж өөрчлөн “, ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн гэсэн байна.

Булгантуяа сайд бас давхар хийчихье. Заалтууд дээр Булгантуяа. Санал хураалт. Тэгье ээ. Санал хураалт 84,6 хувиар дэмжигдсэн байна.

Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.7 дахь заалтын “аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл салбарууд дахь Залуучуудын хөгжлийн зөвлөлүүдийг” гэснийг “аймаг, нийслэл, сум, дүүргийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Тэмүүлэн, Х.Булгантуяа. Санал хураалт. 61,5 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.8 дахь заалтын “Олон улсын байгууллагын” гэснийг хасаж, төрийн бус гэсний дараа “байгууллага” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Х.Булгантуяа. Санал хураалт. 75 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.10 дахь заалтын “Залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээг аймаг, дүүрэг, сум дахь Залуучуудын хөгжлийн төвүүдээр дамжуулан хүргэх, энэ хуульд заасан чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоо” гэснийг “аймаг, дүүрэг, сум дахь төвийн хэрэгжүүлэх энэ хуулийн 20.2-т заасан чиг үүргийг гэрээний үндэстэн дээр гүйцэтгэгч залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Х.Булгантуяа. Санал хураалт. 66,7 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.11 дэх заалтын “Энэ хуульд заасан чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоо” гэснийг “энэ хуулийн 19.1-д заасан зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн. Санал хураалт. Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж санал гаргах гишүүд байна уу. Зарчмын зөрүүтэй санал алга байна. Энд бичгээр ирүүлсэн нь төслийн 2 дугаар зүйл дээр зарчмын зөрүүтэй санал гарсан байна. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. 5 санал байна.

6.Төслийн 2 дугаар зүйл буюу 20.2.2 дахь заалтын “гаргах үйл ажиллагаанд бүх түвшинд оролцож саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх боломжийг бүрдүүлэх” гэснийг “гаргахтай холбоотой саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн. Санал хураалт. Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

7.Төслийн 2 дугаар зүйл буюу 20.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.2.5.гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, тулгамдсан бэрхшээлийг даван туулах талаар залуучуудад сургалт явуулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх,” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн. Санал хураалт. 75 хувиар дэмжигдлээ.

8.Төслийн 2 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “үйлчилгээ болон энэ хуульд заасан” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн. Санал хураалт. 66,7 хувиар дэмжигдлээ.

9.Төслийн 2 дугаар зүйл буюу 20.4 дэх хэсгийн “төвийг” гэснийг “төвийн үйл ажиллагааны зардлыг” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн. Санал хураалт. 66,7 хувиар дэмжигдлээ.

10.Найруулгын санал.

Төслийн 2 дугаар зүйл буюу 20.2.3 дахь заалтын “сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн” гэснийг “сонирхлын бүлгийн” гэж, 20.2.7 дахь заалтын “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 20.3 дахь хэсгийн “, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоогоор” гэснийг “залуучуудын иргэний нийгмийн байгууллагаар” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн. Санал хураалт. 75 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуух гишүүн байна уу. Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй

санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. 2 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу.

Төслийн 1 дүгээр зүйл дээр зарчмын зөрүүтэй санал гарсан байгаа. Та бүхэнд бичгээр тараасан. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. 3 санал байгаа. Уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 40.5 дахь хэсгийн “хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд тавигдах” гэснийг “хуулийн 23.2-т заасан” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн. Санал хураалт. Санал хураалт 75 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйл буюу 46 дахь хэсгийн “томилсон тохиолдолд байгууллага дэд даргатай байна” гэсний дараа “энэ тохиолдолд Төлөвлөлтийн тухай хуулийн 50.5.1 дэх хэсэг хамаарахгүй” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн. Санал хураалт. Санал хураалт 66,7 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйл буюу 40.7 дахь хэсгийн “заасан байгууллагын” гэснийг “заасны дагуу томилогдсон” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн. Санал хураалт. 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

5.Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 1 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. 2 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна. 1 дүгээр зүйл дээр бас Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу санал гарсан байна. Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Баделхан, Булгантуяа, Мөнхбаатар, Пүрэвдорж нарын зүгээс зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасан байгаа. Томъёоллыг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3.15 дахь хэсгийн “судалгаа эрдэм шинжилгээ туршилт зохион бүтээхтэй холбоотой” гэснийг “шинжлэх ухааны суурь хавсарга технологи, хөгжүүлэлтийн туршилт судалгаа болон инновацын судалгааны” гэж өөрчлөх гэсэн саналыг ирүүлсэн байна. Энэ саналтай холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Санал хураалт.

Би сая бас яасангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөх саналыг гаргая. Сая бас та анзааргагүй байж байгаад дарж чадсангүй ээ. Дахин санал хураалт явуулъя гэсэн хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Саяын өмнөх санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт байгаа. 75 хувиар дэмжигдлээ.

Энэ дэмжигдсэн учраас сая түрүүн уншсан Баделхан, Булгантуяа, Тогтохсүрэн, Мөнхбаатар, Пүрэвдорж нараас гаргасан саналаар санал хураалтыг явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3.15 дахь хэсгийн “судалгаа эрдэм шинжилгээ туршилт зохион бүтээхтэй холбоотой” гэснийг “шинжлэх ухааны суурь хавсарга технологи хөгжүүлэлтийн туршилт судалгаа болон инновацын судалгааны” гэж өөрчлөх. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. 75 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Энд 2 дугаар зүйлтэй холбогдолтой 1 санал байгаа.

Төслийн 2 дугаар зүйлийн “баталсан өдрөөс” гэснийг “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Булгантуяа гишүүн. 66,7 хувиар дэмжигдлээ.

7.Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 2 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй

санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна

8. “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?. Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Тогтоолын төсөлд тусгуулахаар 2 санал гарсан байна. 2 саналыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дэх заалтын “тогтоолын 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 2.4, 2.5 дахь дэд заалт” гэснийг “тогтоолд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт, мөн тогтоолын 2 дахь заалтад 4 дэх дэд заалт тус тус” гэж, мөн заалтын 4 дэх дэд заалтыг 3 дахь заалт болгон тус заалтын “хүүхдэд” гэснийг “хүүхэд бүрд” гэж, “нөхөн олгох;” гэснийг “нөхөн олгосугай.” гэж тус тус өөрчлөн, мөн заалтын “хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн гаргасан хүсэлтэд үндэслэн” гэснийг хасаж, 5 дахь дэд заалтыг 4 дэх дэд заалт болгон өөрчлөх гэсэн байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал.

Батжаргал гишүүн та санал дээрээ тайлбар хэлэх үү. Батжаргал гишүүн микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Үгүй ээ үгүй энэ ийм Бид нар төсвийн тодотгол дээрээ хүүхэд бүрдээ олгох мөнгөө суулгаад өгчихсөн байхгүй юу. Тэгээд одоо олгож байгаа зарчим юу вэ гэхээр тэртээ тэргүй мэдэгдлээ өгч байж мөнгө нь орж байгаа. Тийм учраас хүсэлт гаргаж гэж илүү үг оруулж байх шаардлагагүй ээ. Энийг нь авчхаад, тэгээд л тэр мэдэгдлээ өгдөг зарчмаараа өгөөд л

мөнгөө авдаг энэ л зарчмаараа явах нь зөв. 91 хувьд нь бол бид ямарваа нэгэн ийм илүү үггүй яваад байгаа хэр нь 9 хувь дээрээ ийм үг заагаад хэрэггүй юм. Нэгдсэн 1 үг томъёотой л байсан нь дээр гэж ийм байдлаар санал оруулж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд тайлбарлая. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Энэ удаагийн өөрчлөлтийг нь сайн ойлгоогүй юм шиг байна. 91 чинь бол өөр шүү дээ. Өрхийн орлого гээд аягүй олон үзүүлэлтүүдээр судалж, үндэслэж өгч байгаа гаргасан тоо. Одоо бол үндсэндээ бараг бүх хүүхдэд л гэсэн үг. Гэхдээ хүүхдийн мөнгө авах шаардлагагүй гэж үзэж байгаа тэрийгээ өөр байдлаар хандивлах ч юм уу эсвэл хүүхдүүдийнхээ сайн сайхны төлөө хөрөнгө оруулалт хүүхдийн төлөө фондод шилжүүлэх тэр сонголтыг нь л олгож байгаа юм. Тийм сонголттой, тийм хүсэлттэй хүмүүс байгаа байхгүй юу. Бас бага биш байгаа. 1,5 их наядаас чинь 1 хувь гэхээр 1 сургуулийн мөнгө 15 тэрбум төгрөг. 2 хувь гэдэг чинь 2 сургууль 30 тэрбум төгрөг. Гэтэл хүүхдийн төлөө фонд дээр чинь 10 хүрэхгүй тэрбум төгрөгтэй. Энийгээ тойрч ямар их хэл ам, улс төр болдог билээ. Ийм боломжийг нь тэр хүмүүст олгож байгаа байхгүй юу. Сонголтыг нь. Тэгэхээр энэ чинь ялгаагүй хүүхэд бүртгэгдэх гээд ялгаагүй. Тийм учраас оруулаад ирчихсэн байгаа зохицуулалтыг нь дэмжээд өгөөч ээ л гэж байгаа юм. Ийм илүү дутуу, ийм жижиг сажиг юмаар битгий эргэж буц л даа. Заавал санал гаргах ёстой биш шүү дээ.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн та нэг дахиад тайлбар хэл дээ. Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ ийм л зүйл байхгүй юу даа. Бид хүүхдүүддээ тэгш хандъя л гэж байгаа бол нэгэн ижил л агуулгатай л хандах ёстой. Тэр

цаад хүүхдийн фондод өгөх барих асуудалд хөндсөн заалтыг бол огт энд хөндөөгүй байхгүй юу. Зүгээр хүсэлт гаргадаг гэдэг үгийг л авчхаж байгаа юм. Тэгээд нийт хүүхдүүд яаж мөнгө авдаг вэ тэр хэлбэрээрээ авъя. Өмнөх жилүүдэд хүүхдийн мөнгөө авдаггүй айл өрхүүд байсан. Тэр үед бид нар хүсэлт гаргана гэсэн үг байгаагүй. Тэгээд яг л тэр зарчмаараа л явах ёстой байхгүй юу.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний гаргасан саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Энэ санал дэмжигдсэнгүй ээ. 33,3 хувиар.

2.Төслийн 2 дахь заалтын “Мөн тогтоолын” гэснийг “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолын” гэж өөрчлөн, төсөлд “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолын 3 дахь заалтын дугаарыг “4” гэж өөрчилсүгэй.” гэсэн агуулга бүхий 3 дахь заалт нэмж, төслийн 3 дахь заалтын дугаарыг “4” гэж өөрчлөх.

Энэ бол техникийн заалт байгаа. Ингээд санал гаргасан Ж.Батжаргал Г.Тэмүүлэн. Санал хураалт. Саяын Батжаргал даргын эхний 1 дэх санал дэмжигдээгүйтэй холбогдуулаад бас 1 зарчмын зөрүүтэй санал гаргаж байна.

Тогтоолын төсөл дээр техникийн шинж чанартай заалт байгаа.

Төслийн 1 дэх заалтын “тогтоолын 2 дахь заалтад дор дурдсан агуулгатай 2.4, 2.5 дахь дэд заалт” гэснийг “тогтоолд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт, мөн тогтоолын 2 дахь заалтад 4 дэх дэд заалт тус тус” гэж, мөн заалтын 4 дэх дэд заалтыг 3 дахь заалт болгон тус заалтыг “нөхөн олгох” гэснийг “нөхөн олгосугай” гэж, 5

дахь дэд заалтыг 4 дэх дэд заалт болгон дугаарыг тус тус өөрчлөх гэсэн техникийн өөрчлөлт байгаа. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн. Санал хураалт. Техникийн санал л юм байна шүү. Ингээд энэ тогтоол боллоо.

9. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна. Тогтоолын төсөлд тусгуулахаар 2 санал ирсэн байна. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор саналыг уншиж танилцуулъя.

Төслийн тогтоох хэсгийн “хэсэгт заасныг” гэснийг “хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг” гэж өөрчлөх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн. Санал хураалт. 76,9 хувиар дэмжигдлээ.

Дахиад нэг санал гарч ирж байна. Энэ протоколд тусгуулах зүгээр санал байгаа юм байна. Сандаг-Очир гишүүн бас мэдэж байгаа байх.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1-д доор дурдсан агуулгатай 6.5.21, 6.5.2 дахь заалт нэмэх гэж орсон байгаа. Тэгээд 6.5.21 нь төрийн өмчийн эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, 6.5.22 нь орон нутгийн боловсролын удирдах байгууллага гээд Пүрэвдорж, Сандаг-Очир, Чойжилсүрэн, Энх-Амгалан гэсэн гишүүд гаргасан байгаа. Л.Энх-Амгалан. Тэгээд энэ нь өөрөө Дэгийн хуулийн 40.3.5-аар шинэ заалт нэмэх боломжгүй болчхож байгаа юм байна. Тэгэхээр дэгийнхээ хуулиар энийг нэмэх боломжгүй юм байна гэсэн саналыг протоколд тусгаж хэлж байгаа шүү.н Протоколд тусгаж байна энэ

асуудлыг. Ингээд санал хураалтыг явуулж дууслаа.

Ингээд хууль тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батсуурь гишүүн танилцуулъя. Батсуурь гишүүн танилцуулна.

Ингээд хууль тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

15.22 цаг.

Дараагийн асуудалдаа орцгооё. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Ингээд Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Жавхлан танилцуулахаар байна. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Эрхэм байнгын хороон дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас экспортыг эрчимжүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7,9 хувиар өсөж, гадаад валютын албан нөөц энэ оны эхний 5 сарын байдлаар 3,8 тэрбум долларт хүрч сайжраад байна.

Эдгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр инфляц төдийлөн буурахгүй, иргэдийн бодит орлогод нөлөөлж байгаа

тул ард иргэдийн орлого амьжиргааг дэмжих зайлиггүй шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын Засгийн газраас иргэдийнхээ орлогын баталгаа, амьдрах орчныг сайжруулах, хотын түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгалаа. Тухайлбал:

1.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрд олгохын зэрэгцээ хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд нөхөж олгох.

2.Тэтгэврийн зөрүүний асуудлыг цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар шийдвэрлэх, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх.

3.Төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчилж, суурь цалингийн хэмжээг нэмэгдүүлэх.

4.Нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын сүлжээг өргөтгөх зэргээр нийслэлийн түгжрэлийг бууруулах арга хэмжээг төсөв хооронд зохицуулалт хийж шийдвэрлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгаад байна.

Төсвийн тодотголын арга хэмжээний үр дүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1,7 их наяд төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлага 1,8 их наяд төгрөгөөр нэмэгдэх бөгөөд нэгдсэн төсвийн нийт алдагдал 1,6 их наяд төгрөг буюу анх батлагдсан дотоодын нийт бүтээгдэхүүний 2,6 хувиас хэтрүүлэхгүй байхаар төлөвлөлөө.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайдад баярлалаа. Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат дарга. 2023 онд төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг танилцуулна. Санал дүгнэлтээ танилцуулна. Занданбат даргын микрофоныг өгье. 6 номер.

Д.Занданбат: Төсвийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2023 оны 6 дугаар сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллагаас дараах дүгнэлтийг гаргаж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20 их наяд 781,9 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34,5 хувь, нийт зарлагын хэмжээг 22 их наяд 371,4 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37,2 хувь, төсвийн алдагдлыг 1 их наяд 589,5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2,6 хувь байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт дараах өөрчлөлтийг оруулсан байна.

Сангийн сайд 2023 оны тодотголын төсөлд 4 их наяд 100,7 тэрбум,

Үндэсний аудитын газар 28,9 тэрбум,

Сангийн сайдын төсөвт төвлөрүүлэх орлого 1 их наяд 675,6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь Аж ахуй нэгжийн орлогын албан татвар 534,8 тэрбум төгрөг. Нэмэгдсэн өртгийн албан татвар 105,4 тэрбум төгрөг, Ашигт малтмалын нөөц ашигласны татвар 673,6 тэрбум төгрөг, Агаарын бохирдлын төлбөр 10 тэрбум төгрөг, бусад татвар 5,3 тэрбум төгрөг, импортын гаалийн албан татвар 124 тэрбум төгрөг, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар 216,5 тэрбум төгрөг, импортын архи, дарсны албан татвар 6 тэрбум төгрөгөөр нэмж төлөвлөснөөс шалтгаалсан байна.

Сангийн сайдын урсгал зардлын төсвийн 27,9 тэрбум төгрөг, Үндэсний аудитын газрын урсгал зардлын 2,3 тэрбум төгрөгийн өсөлт нь төрийн албан хаагчийн цалин хөлсний шинэчлэлттэй холбоотой байна.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Занданбат даргад баярлалаа. Ингээд төсвийн тодотголын төсөл болоод Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн

ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын төсвийн хяналт шинжилгээний асуудлыг хариуцсан нэгж, Төсвийн тогтоолын зөвлөлөөс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд бас хүргүүлсэн байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу бусад Байнгын хороо Төсвийн зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн тодотголын төслийг хэлэлцээд, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд ирүүлнэ гэж заасан байгаа. Ингээд зарчмын зөрүүтэй саналууд бол гараагүй. 10 Байнгын хорооноос. Та бүхэнд энэ 10 Байнгын хорооноос ирүүлсэн санал, дүгнэлтүүдийг бичгээр хүргүүлсэн байгаа. Тэгэхээр уншихгүйгээр бүгдийг нь бас танилцсанд тооцлоо гэсэн, сонссонд тооцлоо гэсэн горимын саналыг гаргаж байна. Энэ горимын саналыг бүгд дэмжиж байгаа байх. Нөгөө 10 Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцлаа гэдгээр горимын санал гаргаж байна. Үүгээр санал хураагаад нэг мөр албажуулчихъя. Санал хураалт.

Баделхан гишүүнийх үү. Тэгвэл Баделхан гишүүн та горимын санал гаргачих.

Х.Баделхан: Энэ санал хураалтыг дахиж явуулж өгнө үү. Саяын дараад орсонгүй.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Тэгвэл саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Баделхан гишүүний саналаар санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай санал хураалт. Ингээд 66,7 хувиар дэмжигдсэн байна. Одонтуяа гишүүн дэмжсэн протоколд авчихъя.

Суулийнх нь Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг

Улсын Их Хурлын гишүүн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Бөхчулууны Пүрэвдорж гишүүн танилцуулахаар байна. Пүрэвдорж гишүүнийг дуудъя. Саяын Баделхан гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас горимын саналаар 10 Байнгын хорооноос ирүүлсэн санал, дүгнэлтүүдийг бичгээр та бүхэнд тарааж, ямар нэгэн зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас танилцсанд тооцно гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт гишүүд анхааралтай байгаарай. 75 хувиар дэмжигдсэн байна. Бүх Байнгын хорооны санал дүгнэлтүүдийг танилцаж дууслаа.

Ингээд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Бөхчулууны Пүрэвдорж гишүүнд танилцуулна. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан 2023 оны төсвийн тухай, 2023 оны нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай, 2023 оны эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо 2023 оны 6 сарын 14-ний өдөр хуралдаж хэлэлцсэн.

Энэ хэлэлцэх явцад дараах саналуудыг гаргасан байгаа. Тэгэхээр юуны өмнө Төсвийн зарлагын хяналтын дэд хороо бол дээрх хуулиудаар хүүхдийн мөнгийг 100 хувь болгох, мөн түүнчлэн цалин тэтгэвэр нэмэх тухай асуудлыг дэмжсэнийг юуны өмнө хэлэх нь зүйтэй байх.

Тэгэхээр энэ төсвийн тодотгол хийсэнтэй холбоотойгоор бас тодорхой эрсдэлүүд, асуудлууд гарах ийм магадлал маш их өндөр байна гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл цалин тэтгэвэр нэмснээр, хүүхдийн мөнгийг 100 хувь олгосноор зах зээл рүү их хэмжээний мөнгө орсны үндсэн дээр үнийн өсөлт их хэмжээгээр нэмэгдэх ийм эрсдэл байна.

Тийм учраас зэрэгцсэн үнийн өсөлтийг хэт өндөр байлгахгүй, инфляцыг нам түвшинд байлгах, тэр арга хэрэгслүүдийг Засгийн газар параллельный авч хэрэгжүүлэх ёстой. Мөн түүнчлэн хувийн хэвилийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор хөрөнгийн дутагдлууд гарах ийм магадлал өндөр байна. Үйл ажиллагаа доголдох ийм эрсдэл байж байна гэж үзэж байгаа. Энэ цалин тэтгэвэр нэмсэнтэй холбоотойгоор төсвийн алдагдал оны эцсээр бий болж магадгүй. Яагаад гэвэл 50 сая тонн нүүрсийг экспортолно. Түүний үнэ нь 140 доллар байна гэж Засгийн газар тооцож оруулж ирсэн. Гэтэл өнөөдрийн байдлаар БНХАУ-ын Чинхандо боомт дээр сайн чанарын коксожсон нүүрс бол өнөөдрийн байдлаар 108 доллар байгаа. Цаашидаа 85 доллар руу унах ийм эрсдэл байна. Тийм учраас энэ нүүрсний экспортоос орж ирэх орлого тодорхой хэмжээгээр багасах, үүнээс үүдээд төсвийн алдагдал нэмэгдэх ийм нөхцөл бий болох юм байна. Тийм учраас бусад орлогыг сайжруулах энэ ажлыг өндөр түвшинд хийх ёстой. Тэгэхээр энэ оны эхний 4 сарын байдлаар бол нүүрснээс орж ирж байгаа орлого 54 хувиар өссөн. Татварын орлого ялангуяа энийг би инфляцын татвар гэж ойлгож байгаа.

Өөрөөр хэлбэл инфляц буюу барааны үнэ өссөнтэй холбоотойгоор татварын орлого нэмэгдэж байгаа. Тийм учраас энэ орлого хэдийгээр нэмэгдэж байгаа боловч энэ нүүрсний экспортын үнэтэй холбоотойгоор орлого буурах ийм эрсдэл байгаа учраас төсвийн

алдагдлаа нэмээд түүгээрээ уламжлалт аргаараа буюу гадаадаас зээл авах замаар хаах ийм нөхцөл рүү оны эцэс рүү орж магадгүй. Тийм учраас бусад орлогыг нэмэгдүүлэх талаар Засгийн газар ажиллах нь зүйтэй гэж үзсэн.

Инфляцын татварын хэмжээ нэмэгдэж байна. Тийм учраас энэ инфляцын татварыг хазаарлах, өөрөөр хэлбэл инфляцыг нам түвшинд байлгах тэр ажлыг зайлиггүй хийх ёстой. Энэ зах зээл рүү их хэмжээний мөнгө орсноор валютын ханиш чангарч, төгрөгийн ханиш сулрах ийм нөхцөл байдал руу орно. Тийм учраас өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг ялангуяа гадаадаас импортлож байгаа бараа бүтээгдэхүүний үнийг нам түвшинд байлгах, мөн түүнчлэн ложистикийн хямралтай холбоотой барааны үнийн өсөлтийг шийдвэрлэх талаар Засгийн газар ажиллах ёстой гэж үзэж байгаа.

Гадаадын хөрөнгө оруулалт. Өөрөөр хэлбэл инфляц өндөр бай энэ тохиолдолд болон гадаадын хөрөнгө оруулалт багасах ийм эрсдэл байна. Тэгээд энэ бүхний үндсэн дээр орлого буурч магадгүй тул оны эцсээр цалин тэтгэврээ тавих, хүүхдийн мөнгийг олгох, бусад төрийн зардлуудыг гаргах тэр зардал гаргаж чадахгүй байх ийм нөхцөл байдалд очиж магадгүй шүү гэдгийг бас энэ Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хурлын явцад бас анхааруулж хэлснийг мэдэгдье. Засгийн газар Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхийн зэрэгцээгээр хувийн хэвилийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих тал дээр маш сайн ажиллах ёстой. Хувийн хэвшилд бизнесээ өргөжүүлэх, үйл ажиллагаа явуулахад аливаа нэг төрийн дарамтыг багасгах энэ чиглэлдээ илүү сайн ажиллаж байж энэ төсөвт төвлөрч байгаа татварын орлого нэмэгдэх ийм боломж бүрдэнэ гэдгийг бас анхааруулж хэлье.

Тэгээд Байнгын хорооны эрхэм гишүүд та бүхэн Монгол Улсын 2023 оны

төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, мөн Эрүүл мэндийн даатгалын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хэлэлцээд та бүхэнд санал, дүгнэлтээ хүргүүлсэн байгаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Бөхчулууны Пүрэвдорж даргад баярлалаа.

Ингээд Байнгын хороодын санал, дүгнэлт болоод Зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг сонсож дууслаа. Хууль санаачлагч болоод Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Урьдчилан бичгээр томъёолж ирүүлсэн саналуудаар санал хураалтыг явуулах нээлттэй байгаад байгаа. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Гишүүдээс гарах саналууд микрофоноо аваад танилцуулаарай. Одонтуяа гишүүн, Сандаг-Очир гишүүн. 2 гишүүн байна. Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: 1 ийм асуудал байгаа юм. Би нөгөө үнийн дүнд ямар ч хамааралгүй текст дээр 1 үг нэмэх заалт байгаа юм. Энийг ажлын хэсгийн, Байнгын хорооны гишүүдийг дэмжээд өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Энэ нөгөө Эдийн засгийн байнгын хороон дээр энэ уначихсан юм байна лээ. Тэгэхээр энэ унасан саналыг нь би татаж аваад, Төсвийн байнгын хорооныхонтой яриад текстийг нь зөв болгочихсон. Үүнийг уншихаараа гишүүд дэмжээд өгөөч ээ. Ямар нэгэн үнийн дүнд ямар ч хамаарал байхгүй зүгээр нэг үг л нэмэх юм. Ажил нь явахгүй гацаад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Та томъёоллыг нь уншаад танилцуулаадах уу.

С.Одонтуяа: Төслийн 1 дүгээр хавсралтын “Ард Аюушийн өргөн чөлөөний гэрэлтүүлэг” гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн нэрийг “Ард Аюушийн өргөн чөлөөний болон Төв гудамжны гэрэлтүүлэг, Улаанбаатар Баянгол дүүрэг” гэж өөрчлөх. Өөрөөр хэлбэл төв гудамжнуудын гэрэлтүүлэг гэдэг л үг нэмэх юм. Тэгээд энэ нь орхигдчихсон болохоор энийг үнийн дүнд өөрчлөлт орохгүй учраас дэмжиж өгөөч л гэж хүсэж байгаа юм. Нэг л үг нэмэх юм байгаа юм.

Г.Тэмүүлэн: Нэршил дээр нэг үг оруулж байгаа юм байна шүү дээ. Хуучин “Ард Аюушийн өргөн чөлөөний гэрэлтүүлэг” гэснийг “Ард Аюушийн өргөн чөлөөний болон төв гудамжнуудын гэрэлтүүлэг гэж” төв гудамжнуудын гэж үг нэмж байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр Сангийн яам тайлбар хэлэх үү. Санхүүжих дүнд өөрчлөлт орохгүйгээр нэршилд өөрчлөлт ороход хуулийн хийдэл асуудал үүсэх, эсэх талаар. Тэгэхээр бараг тендер нь зарлагдсан уу эсвэл өмнөх юугаараа хэрэгжчихсэн явж байгаа байх. Сангийн яамнаас хариуцсан хүн байна уу. Хөрөнгө оруулалт хариуцсан.

Чимэдсүрэн дарга, та энэ асуудлыг. Томъёоллыг сонссон уу. 6 номер.

Ч.Чимидсүрэн: Засгийн газрын түвшинд энэ төсвийн тодотгол ярьж байхад үг, үсгийн ийм саналууд бол яригдсан болж. Энэ бол огт авагдаагүй. Яг энэ тухайлсан Одонтуяа гишүүний хэлсэн энэ төслийн тендер нь энэ нэр томъёогоороо зарлагдчихсан байгаа учраас одоо бас хүлээж авахад боломжгүй л тийм төсөл байгаа юм.

Г.Тэмүүлэн: Одонтуяа гишүүнээс ирүүлсэн санал. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт 33,3хувиар энэ санал дэмжигдсэнгүй ээ.

Сандаг-Очир гишүүн. Сандаг-Очир гишүүн саналаа танилцуулъя.

Ц.Сандаг-Очир: Би төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн ерөнхийлөн захирагч руу зардал хооронд зохицуулалт хийх зарчмын зөрүүтэй санал гаргах гэж байгаа юм. Тухайлбал Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Амарбаясгалан даргын багцаас Амарсайхан Шадар сайдын багц руу. Тэгээд санаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо уншаадахъя.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэн газрын даргын төсвийн багцын байгууллага болох Шадар сайдын ажлын албаны урсгал төсвийн гамшигаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, шалгах зардлын ангилалд батлагдсан хөрөнгийн эх үүсвэрээс 1 тэрбум 600 сая төгрөгийг Онцгой байдлын ерөнхий газрын багаж техник хэрэгслийн зардалд 1 тэрбум төгрөгийг, гамшигаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны зардалд 600 сая төгрөгийг тус тус зардлын ангилалд тусгаж өгнө үү.

Амарбаясгалан даргынх нь бичиг энд байна.

Г.Тэмүүлэн: Шадар сайд зөвшөөрсөн.

Ц.Сандаг-Очир: Гамшигаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, шалгах зардлын ангилал. Хэрэг эрхлэх дээр зардал нь гарахгүй байгаа юм шиг байна лээ. Энэ чиглэлээрээ. Тэр Онцгой байдал Шадар сайд дээр байж байж чиг үүргээрээ гэж танай Сангийн яамныхан бүгд ойлгож байгаа юм гэсэн шүү дээ.

Г.Тэмүүлэн: Сангийн яам тайлбар өгөх үү. 2 номер Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дотор Шадар сайдын ажлын алба байдаг. Шадар сайдын ажлын алба дотор гамшиг ослын судалгаа хийх гээд 1 тэрбум 600 сая төгрөг байгааг Онцгой байдлын ерөнхий газар буюу тэр чиг үүрэгтэй нь холбоотой газар руу нь шилжүүлбэ гэдэг бичиг бол Сангийн яаман дээр ирсэн. Гэхдээ Засгийн газрын бодлогын хүрээнд бол бид нар зөвхөн цалин, тэтгэвэр, халамжтай холбоотой зохицуулалт хийж байсан учраас энэ зардлыг оруулж ирээгүй, Засгийн газраар ороод хуралд төсвийн тодотголын төсөл бол өргөн баригдсан байгаа.

Санал гаргах эрх нь Улсын Их Хуралд байгаа. Зүгээр Засгийн газрын бодлогын хүрээнд бол бид нар зөвхөн цалин, халамж, тэтгэвэртэй холбоотой энэ зохицуулалтыг оруулж ирснээс биш өөр илүү ямар нэгэн зардал бол бид нар нэмж хасаж бол оруулж ирээгүй.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Санал гаргах эрх нь бол гишүүдэд нээлттэй байгаа. Санал хураалт. 25 хувиар дэмжигдсэнгүй. Өөр саналтай гишүүн Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Зарчмын зөрүүтэй саналын томъёолол. 2023 оны төсвийн тухай хуулийн хавсралт “Х. 1.1.260 Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал, спорт заал /Хөвсгөл, Мөрөн сум, Титэм сургууль/, төсөвт өртөг 9 тэрбум 673 сая, санхүүжих дүн 3 тэрбум” гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнгээс 340 сая төгрөгийг хасаж, мөн хавсралтын “Ш.1.24 дэх багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Ховд/ төсөвт өртөг 3 тэрбум 611,3, санхүүжих дүн 2 тэрбум 711” гэсэн төсөл арга хэмжээний эдийн засгийн ангилалд тоног төхөөрөмж гэж нэмэн,

санхүүжих дүнг 340 сая төгрөгөөр нэмэх зарчмын зөрүүтэй. Саналын томъёолол гаргасан Их хурлын гишүүн Пүрэвдорж, Сандаг-Очир, Чойжилсүрэн, Л.Энх-Амгалан. Санал хураалгаж шийдвэрлэж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Үр дүнд нөлөөлөхгүй зарчмын санал байгаа.

Төслийн 1 дүгээр зүйлийн “2 дахь заалт буюу 6 дугаар зүйл” гэснийг “6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг” гэж өөрчлөх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн. Санал хураалт 58,3 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлийн “1 дүгээр хавсралтаар” гэснийг “энэ хуулийн хавсралтаар” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн. Санал хураалт. Гишүүд дэмжээрэй. 66,7 хувиар дэмжигдлээ.

3 дахь нь. Төслийн 1 дүгээр хавсралтын “ХИИ.3.3.Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Төв, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Ховд, Хөвсгөл/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн нэрийн “Хөвсгөл” гэснийг “Говь-Алтай” гэж өөрчлөх гэсэн санал байгаа. Санал гаргаж байгаа нь Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн, Б.Энх-Амгалан гэсэн гишүүд байгаа. Санал хураалт. 41.7 хувиар дэмжигдсэнгүй.

2.Бусад Байнгын хорооноос ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол байгаа. 2 Байнгын хороон дээрээ дэмжигдээгүй 2 санал байна.

1 дүгээрт нь. Төслийн 1 дүгээр хавсралтын 10.1.1.65 сургуулийн барилга 720 /Улаанбаатар Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/, хэрэгжих хугацаа нь 2019-2023 он, төсөвт өртөг нь 7 тэрбум 593,9 сая төгрөг. 2023 онд санхүүжих дүн нь “1 тэрбум 86,3 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн төсөвт өртөг “7 тэрбум 593,9 сая төгрөг” гэснийг 10 тэрбум 246,9 сая төгрөг гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжээгүй санал байна. Дэмжээгүй саналыг дэмжье гэдгээр санал хураах нь байна шүү. Гишүүд санал хураалт. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэдгээр санал хураах нь байна. Үнийн дүн хүсэлттэй юм байна. Цогтбаатар гишүүнээс гаргасан санал байна. 75 хувиар дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр хавсралтын 9.1.112.“Ард Аюушийн өргөн чөлөөний гэрэлтүүлэг /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн нэрийг төслийн нэрийг “төв замуудын гэрлэн чимэглэл Улаанбаатар, Баянгол Баянгол дүүрэг/ гэж өөрчлөх Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа. Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал байгаа юм байна. Санал хураалт 66,7 хувиар дэмжигдлээ. Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хураалтыг явуулж дууслаа.

Ингээд Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын 2 дахь хэлэлцүүлгийг хийсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг миний бие өөрөө нэгдсэн хуралдаанд танилцуулъя.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Байнгын

*хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.
Байнгын хороо болоод ажлын хэсгийн
гишүүд баярлалаа.*

16.03 цаг.

***Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ***

Э.СУВД-ЭРДЭНЭ